

2024 оны 03 сарын 21-ны өдөр

№ 09

Улаанбаатар хот

Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.17 дахь заалт, Компанийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Гүйцэтгэх захирал /М.Одгэрэл/-д, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Э.Цэлмэг/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ






Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны ...03 сарын 21-ны өдрийн ...09 тоот Тогтоолын Хавсралт №01

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү “Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр” /цаашид “Хөтөлбөр” гэх/-ийн зорилго нь “Сэндли ББСБ” ХК /цаашид “Компани” гэх/-ийн компанийн хувьцаа эзэмшигч, ирээдүйн хөрөнгө оруулагч, санхүүгийн зах зээлд оролцогчдод (итгэлцэл, бонд авсан иргэн, хуулийн этгээд хамаарна) /цаашид нийтэд нь “Хөрөнгө оруулагч” гэх/ компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц үйл явдал, компанийн стратегийн хэрэгжилт, хэтийн төлөв, санхүүгийн гүйцэтгэл болон шаардлагатай бусад цаг үеийн мэдээллийг хүргэх, мэдээлэл солилцох, хөрөнгө оруулагчаас санал, хүсэлт, гомдол хүлээн авах, компанид хөрөнгө оруулалт хийх хүсэлт, сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдтэй харилцаа тогтоох, мэдээлэл солилцох зарчим, арга замыг тодорхойлоход оршино.
- 1.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хөрөнгө оруулагчдыг тогтмол хугацаанд үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь хангах, Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулагчийн санал хүсэлт хүлээн авах сувгийг бий болгох, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх, компанийн хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангах, хувьцаат компанийн мэдээллийн ил тод байдлыг олон улсын түвшинд хүргэхэд зорино.

Хоёр. Хөрөнгө оруулагчтай харилцах зарчим

- 2.1 Хөрөнгө оруулагчид мэдээлэл хүргэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.1.1 Хөрөнгө оруулагчийн мэдээлэлд хандах эрхийг хүртээмжтэй байлгах, компанийн нээлттэй мэдээлэлд хандах, түүнтэй танилцах нөхцөлийг бүрдүүлэх;
 - 2.1.2 Мэдээлэл нь үнэн зөв, хоёрдмол утга агуулаагүй, бүрэн гүйцэд, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэгдсэн байх;
 - 2.1.3 Хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй байршуулах;
 - 2.1.4 Хууль тогтоомж өөрчлөгдсөн, үйл ажиллагаа өөрчлөгдсөн, шинэ технологийн шийдэл нэвтрүүлсэн зэрэг аливаа шалтгааны улмаас олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр мэдээлэх;
- 2.2 Хөрөнгө оруулагчийн санал, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэхэд дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.2.1 Хөрөнгө оруулагчтай найрсаг, хүндэтгэлтэй хандах;
 - 2.2.2 Хөрөнгө оруулагчийн зорилго, тулгарсан асуудлыг анхааралтай бүрэн дүүрэн сонсох;
 - 2.2.3 Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой сайжруулах боломжтой дэвшүүлж буй санал, тайлбар хариу хүссэн хүсэлтийг тодруулан, эргэлзээгүй болгох зорилгоор тодорхойгүй асуудлыг асууж лавлах;

- 2.2.4 Хөрөнгө оруулагчид тулгарсан аливаа асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, түргэн шуурхай, зохих цаг хугацаанд нь шийдвэрлэх; шийдвэрлэлтэд эргэн хяналт тавих;
- 2.2.5 Хөрөнгө оруулагчийн аливаа үйлдэлд уучлалт хүсэх, талархал илэрхийлэх зэрэг идэвхтэй хариу үйлдэл үзүүлэх;
- 2.3 Хөрөнгө оруулалт хийх хүсэлт, сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдтэй харилцаа тогтоох, мэдээлэл солилцоходоо дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 2.3.1 Компанийн урт хугацааны болон богино хугацааны стратеги, тухайн жилийн бизнес төлөвлөгөөнд нийцсэн байх;
 - 2.3.2 Хөрөнгө оруулалт хийх хүсэлт, сонирхол бүхий хувь хүн, хуулийн этгээдэд хүргэж байгаа аливаа төрлийн мэдээлэл нь хоёрдмол утга агуулаагүй, үнэн зөв, бүрэн гүйцэд, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх;
 - 2.3.3 Нийтэд нээлттэйгээс бусад төрлийн мэдээлэл өгөх тохиолдолд нууц хадгалах гэрээ байгуулах;
 - 2.3.4 Санал болгож буй компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын санал нь түүний хүсэл, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг тодруулж, хөрөнгө оруулагчийн хүсэл, шаардлагыг үнэн зөв, тодорхойлсон байх;

Гурав. Хөрөнгө оруулагчтай харилцах, мэдээлэл солилцох

- 3.1 Компани нь хөрөнгө оруулагчдад нийтэд ил тод мэдээллийг хүргэх суваг нь компанийн алба ёсны цахим хуудас болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас байна. Компани дараах мэдээллийг компанийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүр хүргэнэ. Үүнд:
 - 3.1.1 Хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан;
 - 3.1.2 Хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан;
 - 3.1.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдэгдэл, хурлын материал;
 - 3.1.4 Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон нөхцөл байдалтай холбоотой мэдээлэл;
 - 3.1.5 Зах зээлийн судалгаа, шинжээчийн дүгнэлт;
 - 3.1.6 Хөрөнгө оруулагчдын ирүүлсэн санал хүсэлт, гомдол болон шийдвэрлэсэн байдал;
 - 3.1.7 Компанийн нийгмийн хариуцлагын мэдээлэл;
 - 3.1.8 Бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээрийн өөрчлөлт шинэчлэлтийн талаарх мэдээлэл;
 - 3.1.9 Компани болон хөрөнгө оруулагч шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;
- 3.2 Компанийн нийтэд ил тод мэдээлэх мэдээллээс бусад мэдээлэл болон хөрөнгө оруулагчтай байгуулсан гэрээ, хэлцлийн хүрээнд мэдээлэх мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх тохиолдолд гарт нь эсхүл албан ёсны цахим шуудангийн хаягаар илгээх замаар хүргэх бөгөөд Мэдээллийн аюулгүй байдлын журмын хэрэгжилтийг хангана.
- 3.3 Шаардлагатай тохиолдолд Компани нь хөрөнгө оруулалтын зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллага, хувь хүн, үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдоор дамжуулан буюу гэрээ байгуулсны үндсэн дээр хөрөнгө оруулагчидтай харилцаа тогтоох, мэдээлэл солилцож болно. Энэ тохиолдолд энэхүү журмаас гадна тухайн гуравдагч этгээдтэй байгуулах гэрээг удирдлага болгоно.

Дөрөв. Хөрөнгө оруулагчаас санал хүсэлт, гомдол хүлээн авах

- 4.1 Хөрөнгө оруулагч нь санал хүсэлт, гомдлыг contact@sendly.mn цахим шуудан болон компанийн олон нийтийн цахим сүлжээний хаягуудаар (Facebook: Sendly, Sendly хэрэглэгчдийн групп, Sendly хувьцаа эзэмшигчид, сонирхогчид) дамжуулан цахимаар гаргах, 77997700 тоот утсанд хандан амаар гаргах, эсхүл бичгээр компанийн албан ёсны хаягт ирүүлнэ.
- 4.2 Хөрөнгө оруулагч нь санал, хүсэлт, гомдлыг гаргахдаа өөрийн овог нэр, холбоо барих утасны дугаар, оршин суугаа хаяг болон санал, хүсэлт, гомдол гаргасан огноо зэрэг мэдээллийг зайлшгүй тусгасан байна. Энэхүү шаардлагыг хангаагүй хүсэлт, гомдлыг хүлээн авахгүй.
- 4.3 Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг тэр даруй ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлэх бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь нөхцөл байдлыг тодруулж, компанийн холбогдох албан тушаалтантай хамтран шийдвэрлэх, хөрөнгө оруулагчид хариу хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана.
- 4.4 ТУЗ-ийн нарийн бичгийн даргад санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч бүртгэх бөгөөд ийнхүү хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ. Хэрэв шаардлагатай бол компанийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хугацааг дахин ажлын 10 хүртэл хоногоор сунгана.

Тав. Хариуцлага

- 5.1 Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Хөрөнгө оруулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнан ажиллана.
- 5.2 Энэхүү хөтөлбөрийг зөрчсөн болон хөрөнгө оруулагчийн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх ажиллагаанд оролцсон холбогдох ажилтны үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжтэй тохиолдолд компани холбогдох хууль, хяналтын байгууллагад хандаж шалгуулна.
- 5.3 Хөтөлбөрийн 5.2-т заасны дагуу буруутай этгээдэд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулсан эсэхээс үл хамааран Компани нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журам, бусад дотоод дүрэм, журамд заасан сахилгын шийтгэлийг ногдуулна.

Зургаа. Бусад

- 6.1 Энэхүү хөтөлбөр нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.2 Энэхүү хөтөлбөрийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах эрх гагцхүү ТУЗ-д хадгалагдана.
- 6.3 Хөтөлбөрийг хэрэгжилтэд компанийн ТУЗ хяналт тавьж ажиллана.
- 6.4 Энэхүү хөтөлбөрөөр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын холбогдох хууль, тогтоомж болон компанийн дүрэм, журамд заасны дагуу зохицуулна.